



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/96

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын замын тэмдэг, тэмдэглэгээ хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг - Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: С.Мөнхтуяа - Хот тохижуулах газрын нягтлан бодогч

Ч.Мөнхтөр - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Н.Алтангэрэл - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга Э.Цолмон - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Эрдэнэцэцэг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Цолмон) -д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД